



**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШАЛ**

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар A/819

Улаанбаатар хот


Г Боловсролын зээлийн сангийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.5 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам", Монгол Улсын Их хурлын 2012 оны "Төрөөс соёлын талаар баримтлах бодлого батлах тухай" 52 дугаар тогтоолын 4.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хавсралтад дурьдсан нэр бүхий иргэдийг 2018 оноос эхлэн Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр гадаадын их, дээд сургуулийн магистрантурт суралцуулсугай.
2. Суралцагчидтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэлийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /М.Ариунжаргал/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Т.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД

ЦОГЗОЛМАА



Боловсрол, соёл, шинжлэх ухаан,
спортын сайдын 2018 оны 12 дугаар
сарын 21-ны өдрийн 17:19 тоот
тушаалын хавсралт



Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр
гадаадын их, дээд сургуулийн магистрантурт
суралцах оюутнуудын нэрс

№	Овог	Нэр	Сургууль	Мэргэжлийн чиглэл түвшин	Хугацаа
1	Ганхуяг	Үндраа	Georje Mason University	Хууль, магистр	2
2	Баазар	Ичинноров	BAU International University	Бизнес, удирдлага	2

-оОо-